



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 4/588

Арвайхээр

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.г, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь заалт, Засгийн газрын 2003 оны Тооллогын товыг өөрчлөх тухай 224 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт байгаа мал, тэжээвэр амьтан, хашаа, худаг, тэжээлийн тооллогыг 2021 оны 12 дугаар сарын 07-ноос 17-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Мал, тэжээвэр амьтан, хашаа, худаг, тэжээлийн 2021 оны тооллогыг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: О.Түмэнжаргал (Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга)

С.Цэдэнбалжир (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Цэнгэл (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны дарга)

А.Нямдаваа (Аймгийн Мал эмнэлгийн албаны дарга)

Н.Эрдэнэсүвд (Аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Лхамсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн мэргэжилтэн)

2.Мал, тэжээвэр амьтан, хашаа, худаг, тэжээлийн тооллогын бэлтгэл ажлыг хангах, тооллого явуулах ажлын хэсгийг сумдад байгуулж, ажилтнуудыг сургах, хяналтын тооллого хийх, тооллогын дүнг нэгтгэх үйл ажиллагааны зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

3.Мал, тэжээвэр амьтан, хашаа, худаг, тэжээлийн тооллого явуулахтай холбогдон гарах шууд зардлыг санхүүжүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Тооллогын бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг аймаг, сумын түвшинд хангаж, тооллогыг тогтоосон хугацаанд нь заавар, журмын дагуу чанартай явуулж, дүнг мэдээлэхийг ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101250

D:My Doc. Zahiramj. Zasag darga